



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/49

Булган сум

### Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108-р тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД81-16-20, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 05-ний өдрийн XIX/08 дугаар хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн лифт, хүлээн авахын хэсгийн засвар, тоноглол зураг төсөл зохиогч “Өрнөх гүнт” ХХК-тай 19,800,000 (Арван есөн сая найман зуун мянга), Нэгдсэн эмнэлгийн гадна зам талбайн, засвар, арчлалтын ажлын зураг төсөл зохиогч “Өрнөх гүнт” ХХК-тай 18,900,000 (арван найман сая есөн зуун мянга), Булган сумын 5-р баг, Сансар 1, 2-р садны тохижилтын ажлын зураг төсөл боловсруулсан “Өрнөх гүнт” ХХК-тай 19,500,000 (Арван есөн сая таван зуун мянга), Булган аймгийн Булган сумын Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоомын засвар, шинэчлэлтийн ажлын зураг төсөл зохиогч “Грэйтмаунт консалтинг” ХХК-тай 12,000,000 (арван хоёр сая), Булган сумын Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн амрах чөлөөт цагийн талбайн А хэсгийн тохижилтын ажлын зураг төсөл зохиогч “Грэйтмаунт консалтинг” ХХК-тай 20,000,000 (хорин сая), Булган сумын Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн амрах чөлөөт цагийн талбайн Б хэсгийн тохижилтын ажлын зураг төсөл зохиогч “Грэйтмаунт консалтинг” ХХК-тай 20,000,000 (хорин сая), Булган сумын гэр хороолол, гудамж зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх А хэсэг ажлын зураг төсөл зохиогч “Нарлаг хөхий” ХХК-тай 19,600,000 (арван есөн сая зургаан зуун мянга), Булган сумын гэр хороолол, гудамж зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх Б хэсэг ажлын зураг төсөл зохиогч “Нарлаг хөхий” ХХК-тай 19,600,000 (арван есөн сая зургаан зуун мянга), Булган сумын 5 дугаар баг, 16, 17, 208 дугаар орон сууцны айл өрхөд хэрэгцээний халуун усны шугам татах ажлын зураг төсөл зохиогч “Нарлаг хөхий” ХХК-тай 19,900,000 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгөөр тус тус гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Өрнөх гүнт” ХХК (Ц.Булганчимэг), “Грэйтмаунт консалтинг” ХХК (Г.Билгүүн), “Нарлаг хөхий” ХХК (Б.Мөнхбат)-д тус тус үүрэг болгосугай.

3.Дээр дурдсан ажлуудын зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн бөгөөд аймгийн ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд)-д даалгасугай.

4.Дээрх ажлуудын санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ